



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/192

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдийн эцэг эх багш нарт зориулсан сургалтын Улаанбаатар хотоос ирсэн сургагч багш нарын шатахууны зардалд 1,086.478 (Нэг сая наян зургаан мянга дөрвөн зуун далан найман мянган) төгрөг, Турк улсад эмчлүүлэхэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг хүссэн (Ходоодны хорт хавдартай) Мөрөн сумын иргэн М.Лхагва-Очирт 2,000.000 (Хоёр сая) төгрөг, Нэгдсэн эмнэлгийн эмч ажиллагсдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд 5,000,000 (Таван сая) төгрөг, “Эрүүл мэндийг дэмжих төв”-өөс хариуцан зохион байгуулж буй хүн амыг эрт илрүүлэг, үзлэг оношлогоонд хамруулах үйл ажиллагааны зардалд 5,000,000 (Таван сая) төгрөг, Турк улсад зохион байгуулагдах Дэлхийн оюуны спортын хорооноос зохион байгуулж буй Олон улсын “Ментал арифметик”-ийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол улсаа төлөөлж, оролцох Баянмөнхийн Хонгорзулын замын зардлын дэмжлэгт 1,000.000 (Нэг сая) төгрөгийн нийт 14,086.478 (Арван дөрвөн сая наян зургаан мянга дөрвөн зуун далан найман мянган) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 9,086.478 (Есөн сая наян зургаан мянга дөрвөн зуун далан найман мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, Нэгдсэн эмнэлгийн эмч ажиллагсдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлын 5,000.000 (Таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын ерөнхий дансны “Иргэд байгууллагын асуудал шийдвэрлэх зардал”-аас тус тус гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

671 1010031